



VII-IX/2022

Тархаасан: 2022 оны 10 дугаар сарын 15



Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх улирлаас 13.3 хувиар өсжээ


Манай улсад 2022 оны 3 дугаар улирлын байдлаар гадаадын 92 улсын 7.0 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна.

Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.3 (22.3%) мянган хүнээр, өмнөх улирлаас 0.8 (13.3%) мянган хүнээр өссөн байна. Ажил эрхэлж буй гадаад иргэдийн 6.2 (88.1%) мянга нь эрэгтэй, 0.8 (11.9%) мянга нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн 56.5 хувь нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын, 5.3 хувь нь Бүгд Найрамдах Энэтхэг Улсын, 4.9 хувь нь Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын, 4.5 хувь нь Оросын Холбооны Улсын, 3.8 хувь нь Бүгд Найрамдах Солонгос Улсын, 3.1 хувь нь Америкийн Нэгдсэн Улсын, 3.1 хувь нь Бүгд Найрамдах Турк Улсын, 2.8 хувь нь Австралийн Холбооны Улсын, 2.7 хувь нь Бүгд Найрамдах Филиппин Улсын, 2.4 хувь нь Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын, 10.9 хувь нь бусад улсын харьяат байна.

Насны бүлгээр харьцуулбал 50-54 (16.9%), 45-49 (16.8%) насныхан хамгийн өндөр, 24 хүртэлх (2.8%) насныхан хамгийн бага хувийг эзэлж байна.

ЗУРАГ 1. АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ГАДААДЫН ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар



Ажил эрхэлж байгаа гадаад иргэдийн 2.9 (40.8%) мянга нь Улаанбаатарт, 2.4 (33.7%) мянга нь Төвийн бүсэд, 1.1 (15.8%) мянга нь Зүүн бүсэд, 0.4 (5.7%) мянга нь Баруун бүсэд, 0.3 (4.1%) мянга нь Хангайн бүсэд ажиллаж байна.

Боловсролын түвшнээр харьцуулбал 3.0 (42.1%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 2.5 (35.9%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 692 (9.8%) нь бүрэн дунд, 604 (8.6%) нь тусгай мэргэжлийн дунд, 138 (2.0 %) нь суурь, 109 (1.5%) нь магистр, докторын боловсролтой байна.


Ажил эрхэлж буй гадаад иргэдийн 3.0 (42.4%) мянга нь мэргэжилтэн, 1.6 (22.6%) мянга нь техникч болон туслах дэд мэргэжилтэн, 0.9 (13.3%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын ажилтан, 0.7 (10.2%) мянга нь менежер, 0.6 (8.2%) мянга нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 0.1 (1.8%) мянга нь энгийн ажил, мэргэжил, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 64 (0.9%) нь контор, үйлчилгээний ажилтан, 42 (0.6%) нь худалдаа, үйлчилгээний ажилтнаар ажиллаж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар



Манай улсад 2022 оны 3 дугаар улиралд ажил эрхэлж буй гадаад иргэдийн 2187 (31.1%) нь уул уурхай, олборлолтын, 1641 (23.3%) нь барилгын, 866 (12.3%) нь боловсролын, 748 (10.6%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 513 (7.3%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 419 (6.0%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 205 (2.9%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 455 (6.5%) нь бусад салбарт ажиллаж байна. Ажил эрхэлж буй гадаад иргэд өмнөх улиралтай харьцуулахад боловсрол (229 хүнээр), уул уурхай олборлолтын салбарт (158 хүнээр) хамгийн их нэмэгдсэн байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар, улирлаар



Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг ажиллаж буй байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 6.2 (88.3%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 0.2 (2.8%) мянга нь төрийн бус байгууллагад, 0.2 (2.4%) мянга нь төрийн өмчит аж

ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 45 (0.6%) нь төсөвт байгууллага, 7 (0.1%) нь хувьцаат компани, 0.4 (5.8%) мянга нь нөхөрлөл, хоршоо болон бусад байгууллагад ажиллаж байна.

Ойлголт, тодорхойлолт:

- Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.
- Гадаад иргэдэд ажил эрхлэх үйлчилгээг “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах” тухай хууль, Засгийн газраас тухай бүр батлан гаргадаг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой тогтоол шийдвэрийн хүрээнд үзүүлдэг. “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 15.1.4, 8, 9-р заалтын дагуу “HG”, “O” болон “SH” ангиллын визээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ болон уригч талын хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэдэд ажил эрхлэх зөвшөөрөл олгож байна.
 - ❖ “HG” ангиллын визээр цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээгээр ирж ажиллана.
 - ❖ “SH” ангиллын визээр шашны байгууллагын урилгаар (i) цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид, (ii) цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.
 - ❖ “O” ангиллын визээр төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын урилгаар цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.



Эх үүсвэр:

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2023 оны 01 дүгээр сарын 16

Нийгмийн статистикийн газрын
даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын Өрхөд
суурилсан судалгааны хэлтсийн
статистикч Л.Даваажаргал
Утас : (976-51)-265543



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212